



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 384

Улаанбаатар хот

“МИК Актив Гурав” ХХК-д  
төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээ  
томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8.1 болон Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “МИК Актив Гурав ТЗК” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Лхагважавын Гангэрэл, Атарбаатарын Энхжин, Лосолсүрэнгийн Бямбаа нарыг томилохыг зөвшөөрсүгэй.

2. “МИК Актив Гурав ТЗК” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Лхагважавын Гангэрэл, Атарбаатарын Энхжин, Лосолсүрэнгийн Бямбаа нарт холбогдох хууль тогтоомж болон журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдахаас өмнө “МИК Актив Гурав ТЗК” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэр, түүний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй байхыг дурдсугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000422